

ЗОХИОГЧИД

1. **Х.Бажийхүү.** УСГ тэмгын газрын дарга
2. **П.Бямбацэрэн.** УСГ ийн дарга
3. **Б.Бадамцэцэг.** УСГ-ын макро эдийн засаг, бизнесийн статистикийн газрын орлогч дарга
Г.Орсоо. Макро эдийн засаг, бизнесийн статистикийн газрын мэргэжилтэн
4. **Ц.Цэрэндорж.** МУИС, ЭЗС-ийн Статистикийн тэнхмийн багш, Доктор (Ph), профессор. Судалгааны чиглэл: "Хэрэглээний статистик" Сүүлийн жилүүдийн бүтээл "Орон сууцны статистикийн шинжилгээ" Хүн ам зүйн сэтгүүл №07.
5. **Л.Мянганжаргал.** ХҮДС магистр
6. **Б.Саранчимэг.** УСГ, Хүн ам, нийгмийн статистикийн ахлах мэргэжилтэн.
7. **Г.Элдэв-Очир.** МУИС, ЭЗС-ийн Статистикийн тэнхмийн эрхлэгч, Доктор (Ph), профессор.
Судалгааны чиглэл: "Хэрэглээний статистик", "Эконометрикийн шинжилгээг эдийн засгийн макро болон микро түвшингийн судалгаанд ашиглах арга зүй". Сүүлийн жилүүдэд хэвлүүлсэн бүтээлүүд: "Статистикийн онол" хамтын бүтээл 2002, "The Trends of Mongolian Population Growth" Солонгос улсад хэвлэгдсэн. "Төлбөрийн балансын зарим асуудал" МУИС: Эрдэм шинжилгээний бичиг. 1999
8. **Н.Хүдэрчулуун.** ХҮДС магиср
9. **Д.Ганзориг.** СЭЗДС-ийн багш, МУИС-ийн докторант. Судалгааны чиглэл: "Бизнесийн статистик, эконометрикс". Сүүлийн үеийн бүтээл: "Бизнесийн статистикийн гарын авлага" 1999, "Эдийн засагчад зориулсан дээд математик" 2000, сурх бичгийн хамтран зохиогч.
10. **Ц.Батсүх.** СЭЗДС-ийн тэнхмийн эрхлэгч, Математик эдийн засгийн ухааны Доктор (Ph). Судалгааны чиглэл: "Макро эдийн засгийн ёсёлтийн математик загварчлал", "Нийгэм эдийн засгийн нарийн нийлмэл шугаман бус процессийн чанарын шинжилгээ". Сүүлийн үеийн бүтээл: "Эдийн засагчад зориулсан дээд математик" 2000, сурх бичгийн хамтран зохиогч.
11. **Б.Сарангэрэл, Ц.Тэгшжаргал.** УСГ-ын Макро эдийн засаг бизнесийн тэмгын газрын мэргэжилтэн
12. **О.Туул.** УСГ. Хүн ам, нийгмийн статистикийн газрын ахлах мэргэжилтэн
13. **Д.Цэрэнпил.** МУИС-ийн ЭЗС-ийн Санхүүгийн тэнхмийн зөвлөх профессор. Эдийн засгийн шинжлэх ухааны доктор, профессор. "Санхүү", "Мөнгө зээл", "Хөгжлийн эдийн засаг", "Хөгжлийн эдийн засаг" чиглэлээр судалгааны ажил хийдэг. Сүүлийн жилд хэвлэгдсэн бүтээлүүд: "Санхүүгийн бодлого" УБ 1999; "Диссертаци бичих хамгаалах арга зүйн зөвлөмж" УБ 2001; "Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдлын зарим асуудал" УБ 2002; "Банкны зээлийн шинжилгээ" УБ 2003, (хамтын бүтээл); "Монголын эдийн засаг: шилжилтийн эдийн засгийн асуудал" УБ 1999, "The Mongolian economy"
14. **Д.Тунгалаг.** МУИС-ийн ОУХС-ийн Сургалтын албаны дарга, доктор (PhD), дад профессор. Олон улсын эдийн засгийн харилцааны чиглэлээр судалгааны ажил хийдэг. Сүүлийн жилүүдэд хэвлэгдсэн бүтээл: "Зүүн хойд Азийн төлөв байдал ба Монгол улс" номын хамтран зохиогч, Улаанбаатар, 2003, "Олон улсын статистик" сурх бичиг.
15. **Х.Эрдэнэчулуун.** МУИС, ЭЗС-ийн ЭЗО-ын тэнхмийн багш, Доктор (Ph), профессор. ГЕГ-ийн дэргэдэх Гааль, эдийн засгийн коллежийн захирал. Судалгааны чиглэл: "Шилжилтийн үеийн макро эдийн засгийн тулгамдсан асуудлууд". Сүүлийн үед хэвлэгдсэн бүтээл: "Шилжилтийн эдийн засаг" номын хамтран зохиогч
16. **Б.Батбямба.** магистр
17. **Д.Намжил.** МУИС-ийн ЭЗС-ийн Санхүүгийн тэнхмийн профессор багш, доктор (Ph). "Төрийн санхүү-мөнгөний бодлого" сэдвээр судалгаа хийдэг.
18. **Т.Жааваа.** МУИС, ЭЗС-ийн Нягтлан бодох бүртгэлийн тэнхмийн багш, Доктор (Ph), профессор, Санхүү, удирдлагын бүртгэл, тайлагнал, аудит чиглэлээр судалгаа хийдэг Сүүлийн 3 жилд хэвлүүлсэн бүтээл: "Санхүү, өртөг, удирдлагын бүртгэл", УБ 1998, "Зардал удирдлагын бүртгэл: гарын авлага", УБ 1999, "Удирдлагын нягтлан бодох бүртгэл", УБ 2001, "Санхүү, өртөг, удирдлагын бүртгэл: төлөвшил, шинэтгэл" УБ 2001, "Санхүүгийн мэдээ" сонин 2001 он. №22, 23, 24.
19. **Н.Ганбямба.** УИХ-ын гишүүн, Докторант. Судалгааны чиглэл: Өмч хувьчлал. Бүтээл: "Хувьчлалын мөн чанар", Эдийн засаг: онол, практик 2003.№08.

1

МОНГОЛ УЛСЫН СТАТИСТИКИЙН АЛБАНЫ
ХӨГЖИЛ, ХЭТИЙН ТӨЛӨВ

Х.Бажийхүү

Манай орны хувьд статистик нь өнө эртний уламжлалтай. Бидний өвөг Хүннү нар хүн, малаа тоолж, мод хэрчин тэмдэглэж байсан тухай болон 13 дугаар зуунд хүчирхэг төр улсыг байгуулсан монголчууд байлдан дагуулсан улс орныхоо хүн амыг тоолж, түүнээ үндэслэн албан татвар ногдуулж байсан тухай түүхийн баримт бичгүүдэд тэмдэглэгдсэн байдаг. 1918 онд Гадаад монгол хүн ам, малын тооллого явуулж байсан ба 1922 онд бүх аймаг тарианы газрыг бүртгэж, тариа тарих, өвс хадах газрыг гадаадын хүмүүст ямар журмаар түрээслэж байсныг судалж байв. 1921 онд ардын хувьсгал ялсны анхны өдрүүдээс эхлэн төр, засгаас бүртгэл статистикийн албыг зохион байгуулахыг нэн чухал зорилт болгон хүн ам, эд хөрөнгө, мал тооллого явуулах, улсын бүртгэл мэдээлэл боловсруулж нэвтрүүлэх талаар удаа дараа шийдвэр гаргаж иржээ.

МАХН-ын III их хурлаас too бүртгэл эрхлэх аппарат байгуулан тусгай дагаж мөрдөх дүрэмтэй болгохыг заасны дагуу Улсын анхдугаар их хурал 1924 оны 11 дүгээр сарын 10-нд гаргасан тогтоолдоо "...тус улсын бүх too бүртгэх явдал маш нарийн чухал болох тул одоо too бүртгэх хэлтэс байгуулж уг хэргийг эрхлэн явуулбал зохино" гэж заагаад тус хурлаар батлагдсан Улсын анхдугаар үндсэн хуульд "Улсын аливаа too бүртгэх явдлыг тогтоох"-ыг хуульчлан заасан түүхэн эхлэлтэй билээ. Дээрхи шийдвэрийн дагуу 1924 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр тэр үеийн дотоод яамны бүтцэд too бүртгэлийн хэлтсийг 6 хүний орон тоотойгоор анх байгуулснаар статистикийн албаны суурь тавигджээ.

Засгийн газрын 1926 оны шийдвэрээр бүртгэлийн ажлыг Засгийн газрын дэргэдэх эдийн засгийн зөвлөлд харьяалуулан тусгай хэлтэс байгуулснаар too бүртгэлийн ажил нэлээд тогтвортожиж, улс даяар явуулах тооллогын хөтөлбөрийн асуулт олширч, хүн ам, малын тооноос гадна ажил эрхлэлт, эрдэм боловсрол, өвчлөлт, үйлдвэр, газар тариалан, үл хөдлөх хөрөнгө зэрэг төрөл зүйлээр тооллого явуулдаг болсон байна.

Манай оронд бүртгэл тооцоог нэвтрүүлэх ажил ихээхэн нарийн төвөгтэй байсан боловч төр, засгийн байнгын анхаарал, гадаад орнуудын баялаг

туршлагад тулгуурлан алхам алхамаар амжилтыг олж, хөгжлийнхөө чиг хандлагыг тодорхойлж, ялангуяа ЗХУ (хуучин нэрээр)-ын сэтгэл харамгуй тусlamж дэмжлэг, тус салбарын хамт олны нэр хичээнгүй хөдөлмөрийн үрээр манай орны бүртгэл статистикийн алба нь түүний өмнө дэвшигдэн тавигдсан зорилт, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжил, өсөлтийн дагуу бүхий л талаараа торниг өсч, түүний нийгэмд үзүүлэх үр нөлөө дээшилж, төр, засгийн өдөр тутмын туслагч нь байсаар иржээ.

Статистикийн байгууллагын үндсэн ажил хүн ам, малын тооллого, бүртгэлийг орон даяар зохион байгуулж, төвлөрүүлэн явуулахаас ажлаа эхэлсэн түүхтэй. Мал хөрөнгийн тооллогыг үнэн зөв явуулах нь түүнд ногдох албан татварын хэмжээг тогтоож, тооцохос эхлэн улсын эдийн засагт нэн тэргүүний ач холбогдол бүхий мал аж ахуйн хөгжилд нөлөөлөх нөхцөл шалтгаануудыг тодорхойлох, төр, засгаас хувьсгалын эхний жилүүдэд авч явуулах олон арга хэмжээг боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэж байлаа.

Улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоход статистикийн мэдээллийн үүрэг улам бүр нэмэгдэхийн хирээр түүний бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээ авч байв. 1941 онд тоо залгат, төлөвлөлтийн ажилтай улам нягт холбоотой болсон юм. Энэ үэс шалгат, төлөвлөлтийн ажилтай улам нягт холбоотой болсон юм. Энэ үэс манай орны бүртгэл, статистикийн албаны өмнө улсын төлөвлөгөөний биелэлтийн явцад байнгын хяналт тавих үндсэн нэг үүрэг шинээр нэмэгдэж, улс ардын аж ахуй, соёлыг төлөвлөгөөтэйгээр удирдан хөтлөх чухал хэрэглүүр болсон байна.

Бүртгэл, статистикийн ажил хэлбэр, агуулгын хувьд хөгжин гүнзгийрч, төвлөрсөн удирдлага, нэгдсэн программтай явагдах болж, зохион байгуулалт, аргачлал, арга зүй нь нарийсан боловсронгуй болохын хирээр улс ардын аж ахуйн бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох нөхцөлийг улам бүр бүрдүүлсэн юм.

1948 оноос манай орон хэтийн төлөвлөгөөтэйгээр хөгжих болсон нь улсын төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх, түүнд тулгуурлан хийх тооцоо судалгааны ажлын чанарыг улам дээшлүүлсэн юм. Энэ бүхэнтэй уялдан бүртгэл, статистикийн албаны өмнө шинэ зорилтууд дэвшигдэн, түүнийг зохион байгуулалтын болон бусад бүх талаар сайжруулах шаардлага гарч иржээ.

1960 оноос монголын статистикийн хөгжлийн түүхэнд нэгэн шинэ үе эхэлсэн гэж үзэж болно.

Статистик бүртгэлийн ажлыг нэгдмэл зарчим, аргачлал зохион байгуулалтын үндсэн дээр төвлөрсөн удирдлагаар хангах улсын төв байгууллага болох БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Тоо бүртгэлийн байгууллага ажлыг тогтоож, тооцохос эхлэн үрээр төв газрыг 1960 оны 4 дүгээр сард Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар байгуулж улмаар аймаг, хотод товчоод, суманд бүртгэлийн ажил хариуцсан орлогч дарга нарыг бий болгосон билээ.

Улс орны эдийн засаг, нийгмийн амьдралд гарсан өөрчлөлтүүдийг нэгтгэн дүгнэж, бүртгэл тайлангийн нэгдсэн системийг нэвтрүүлэх, эдийн засаг, статистикийн ажилд индекс, балансын аргыг өргөнөөр хэрэглэх зорилт дэвшигдэн тавигдсан нь тухайн үедээ цоо шинэ ажил байлаа. Статистикийн байгууллагаас 1960-аад оноос эхлэн хөдөө аж ахуй, үйлдвэр, аж ахуйн газруудын анхан шатны болон нягтлан бodoх бүртгэлийн маягт, аргачлалыг шинэчлэн нэг мөр болгож мөрдүүлсэн нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тодорхойлох чухал зэвсэг болсон юм. Манай орны бүртгэл тайлан, мэдээллийн өнөөгийн тогтолцоо нь нэг хэвийн болон салбаруудын онцлогийг тусгасан анхан шатны бүртгэл, нягтлан бodoх бүртгэлийн тайлан тэнцэл, улсын статистикийн мэдээллийн 100 гаруй нэрийн мэдээ, яамдын дотоод мэдээлэл, жил бүр болон тодорхой хугацаатай явагддаг хүн ам, малын тооллого, өрхийн аж ахуйн зэрэг байнгын ба цаг үеийн түүвэр судалгаанууд, нэг удаагийн бүртгэл зэрэг бүрдэж байна. Эдгээрт үндэслэн дотоодын нийт бүтээгдэхүүн, үндэсний тооцоо, улс ардын аж ахуйн үндсэн фонд, нийгмийн нөхөн үйлдвэрлэлийн явц, салбар хоорондын тэнцэл, хүн амын нөхөн үйлдвэрлэлийн хэтийн тооцоо, хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, тарифын өөрчлөлт, өрхийн орлого, зарлага, хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлох зэрэг томоохон ажлуудыг хийж байна.

Ард түмний аж амьдарлын байдлыг судлах, ялангуяа хүн амын хэрэглээ, түүний бүтцийг нарийвчлан судалж, жижиглэн худалдаалах үнийг тогтвортой байлгах нөхцөл боломжийг бүрдүүлэх, нийгмийн янз бүрийн давхрага, хот хөдөөгийн хүн амын амьжиргааны түвшинг судлах явдал 1960-аад оноос хурцаар тавигдсантай холбогдож Статистикийн төв газарт өрхийн төсвийн судалгааны тасгийг нээж 11 аймагт 1000 өрхийг судалгаанд хамруулж байсан нь эдүгээ улам өргөжин 2000 өрх болж улирал тутам дүнг нэгтгэн гаргаж байгаа нь нийгмийн олон үзүүлэлтийг тооцох суурь судалгаа болж байна.

Статистикийн албыг бэхжүүлэх нэг үндсэн нөхцөл нь боловсон хүчнийг бэлтгэх асуудал билээ. 1960-аад оноос энэ чиглэлд төр, засгаас онцгой анхаарч байсны нэг гэрч нь тэр үеийн ЗХУ-ын их, дээд сургуулиудад статистикийн мэргэжлээр олон оюутныг сургаж эхэлсэн бөгөөд 1960 онд МУИС-д шинээр статистикийн ангийг нээж үндэсний статистикийн мэргэжилтнүүдийг сургаж эхэлсэн явдал юм.

Статистикийн томоохон тооллого, судалгааны болон эдийн засаг, нийгмийн байдлын тухай өдөр тутмын мэдээллийг боловсруулахад асар их хөдөлмөр зарцуулалт шаарддаг нүсэр ажил учир үүнийг хөнгөвчлөх талаар дэс дараатай арга хэмжээг авч, томоохон хөрөнгө оруулалтыг энэ чиглэлд хуваарилж байлаа. Тухайлбал, Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор 1961 онд Статистикийн төв газрын дэргэд анхны бүртгэлийн машинт товчоог байгуулж, статистикийн шуурхай мэдээг ширээний товчлуурт машинаар нэгтгэж эхэлсэн нь бүртгэл тооцооны хүнд хүчир ажлыг механикжуулах суурь болж өгсөн юм. 1963 онд бүртгэлийн машинт товчоог станц болгон тооцоолох шивүүрт машинаар тоноглож улмаар 1963 оны хүн амын туршилтын тооллого, 1969 оны хүн ам, орон сууцны тооллого зэрэг томоохон тооцоонуудыг боловсруулсан юм. Манай улсын анхны тооцоолон бodoх төвийг 1974 онд Статистикийн төв газарт

байгуулж Минск-32 машинаар тоноглон улмаар ЕС-1040, ЕС-1045 машинаар өргөтгөн бүх аймаг, нийслэлийг төлөхолбооны шугамаар холбож статистикийн бүх мэдээ тайланг түүгээр дамжуулан авч боловсруул даг болов.

Манай орон 1990-ээд оноос эдийн засгийн шинэ харилцаанд шилжсэнээр өмч хувьчлал эрчимтэй явагдаж, өмчийн олон хэлбэрийн аж ахуйн нэгж бий болсноос нэлэнхүй ажиглалтаар статистикийн мэдээллийг цуглуулж байсан өмнөх аргыг хэрэглэх боломжгүй болж, ихэвчлэн түүвэр судалгаа, нэг удаагийн шинжлэх ухааны бусад олон аргуудыг хэрэглэх шаардлагатай статистикийн шинжлэх ухааны бусад олон аргуудыг хэрэглэх шаардлагатай статистикийн мэдээлэгч нарын үүрэг хариуцлага, албан ёсны болсон юм. Статистикийн мэдээлэлд төр, засгийн байгууллагын оролцоог тодорхойлох, улсын статистикийн мэдээлэлд төр, засгийн байгууллагын оролцоог тодорхойлох, улсын төрийн шинэ тогтолцооны үед статистикийн албаны бие даасан байдлыг төрийн гүйцэтгэх байгууллагын бүрэн эрхийг тодорхойлов.

1994 онд "Статистикийн тухай" хуулийг анх удаа Монгол Улсын Их Хурлаас баталж, 1997 онд уг хуулийг шинэчлэн найруулж гаргасан нь түүхэн ач холбогдолтой арга хэмжээ боллоо. "Статистикийн тухай" хуулинд дээрх шаардлагыг бүрэн тусгасны зэрэгцээ, статистикийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, статистикийн мэдээллийн болон байгууллагын тогтолцоо, төрийн гүйцэтгэх байгууллагын бүрэн эрхийг тодорхойлов.

Статистикийн мэдээллийг цуглуулах, түүнд судалгаа дүгнэлт хийх, аргачлал, ангилалыг олон улсын нийтлэг жишигт тохируулан боловсронгуй болгох талаар 1990 оноос ихээхэн ажил хийж багагүй амжилт олж байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүн, үндэсний нийт бүтээгдэхүүнийг оны болон зэрэгцүүлэх үнээр олон улсын нийтлэг ангилал, аргачлалын дагуу тооцох, үндэсний тооцооны дансуудыг байгуулах ажил хийгдлээ Мөн салбар хоорондын болон нөөц ашиглалтын тэнцэл (хүснэгт)-ийг зах зээлийн эдийн засгийн харилцааны нөхцөлөөр Олон улсын аргачлалын дагуу боловсруулан гаргаж бодлого, үйл ажиллагаанд хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Манай орон 1992 оноос Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын санхүү, банкны байгууллагын гишүүн болсон нь статистикийн салбарт олон улсын тувшинд хамтран ажиллах таатай нөхцөлийг бий болголоо. Олон улсын эдгээр байгууллагын тусламжтайгаар нөхцөлийг бий болголоо. Олон улсын эдгээр байгууллагын тусламжтайгаар "Амьжиргааны түвшин", "Хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэнд", "Цаг ашиглалт", "Ажил эрхлэлт" зэрэг дэлхийн төдий л олон оронд хийгдэж чадаагүй ирүүлж хамтарсан сургалтыг жил бүр зохион байгуулдаг уламжлал тогтлоо.

Сүүлийн жилүүдэд Европын холбооны улсын статистикийн байгууллага, ОХУ, Турк, Герман, БНСУ-ын статистикийн байгууллагатай хамтын ажиллагаа тогтоон, ТАСИС-ын шугамаар бизнес статистик, бизнес регистр, гадаад худалдааны статистик, статистикийн мэдээллийг хэвлэн нийтлэх, тархаах чиглэлээр төслийдийг амжилттай хэрэгжүүлэв.

НҮБ-ын хөгжлийн программ, Хүн амын сан, Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Аж үйлдвэрийн хөгжлийн газар зэрэг төрөлжсөн байгууллагуудтай байнгын хамтын ажиллагаатай байна.

Статистикийн албаны өмнө ойрын жилүүдэд дараахь үндсэн зорилтыг хэрэгжүүлэх шаардлага гарч байна. Статистикийн мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, үзүүлэлт, аргачлалыг олон улсын нийтлэг стандартад нийцүүлэх ажлыг улам эрчимжүүлэх хэрэгтэй байна. Энэ ажилд олон улсын байгууллага, гадаад орнуудтай байгуулсан хамтын ажиллагааг чиглүүлэн зохион байгуулах болно.

Үндэсний тооцооны системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд эдийн засгийн дансуудыг байгуулах, өөрийн орны онцлогт тохирсон ангилалуудыг боловсронгуй болгох, дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоонд далд эдийн засгийн хүрээнд бий болсон нэмэгдэл өргтийг аль болох бүрэн тусгаж оруулах, энэ чиглэлээр судалгаа явуулах зэрэг томоохон зорилтыг хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Төрөлжсөн судалгаанаас гадна иж бүрэн судалгаануудыг хийх, сар, улирлын бүллетең, танилцуулга зэрэг байнга гардаг мэдээллийн судалгаа тайлбарыг илүү дүгнэлттэй болгох, олон улсын болон дотоодын байгууллагуудтай хамтарсан судалгааг өргөжүүлэхэд анхаарч байна. Судалгаа, тооцооны ажилд орчин үеийн техник хэрэгсэл, программ хангамжийг нэвтрүүлж ашиглах ажиллагааг байнга хийж, олон улсын энэ талын ололт амжилтаас хоцрохгүй байх нь чухал юм.

Статистикийн мэдээллийн бодит үнэн зөв байдлыг хангах нь нэг гол асуудал учир статистикийн төв, орон нутгийн байгууллага, ажилтан нэг бүрийн ажлын хариуцлага онцгой үүрэгтэй билээ. Статистикийн мэдээлэгч нар нь эргээд статистикийн мэдээллийг хэрэглэгч болдог харилцан уялдааг мэдээлэгч нарт нарийн ойлгуулах замаар итгэл үнэмшлийг бий болгох нь мэдээний үнэн зөв, шуурхай байдлыг хангахад чухал нөлөөтэй учир сурталчилгааг өргөн хүрээтэй явуулах нь чухал болно.

Орон нутгийн статистикийн албаны чадавхийг дээшлүүлэх асуудалд онцгой анхаарч байна. Энэ нь боловсон хүчиний мэдлэгийг дээшлүүлж, томоохон судалгаа, тооллогыг тухайн орон нутагтаа зохион байгуулж, тэдгээрийн үр дүнд шинжилгээ хийх, техник тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудал хамрагдах юм. 2003 онд сумдын статистикийн мэдээлэл хариуцсан хүмүүсийн бүсчилсэн семинар, сургалтыг тусгай хөтөлбөрөөр зохион байгуулсан нь зохих үр дүнгээ өгөх бөгөөд цаашид ийм сургалтыг системтэйгээр явуулахад анхаарах шаардлага гарч байна.

ҮСГ-ын үйл ажиллагааны мөн чанар эрхэм зорилт нь улс орны эдийн засаг, нийгмийн байдлыг статистикийн шинжлэх ухааны арга зүйг үндэс болгон бодитоогоор дүгнэх, Засгийн газраас эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг, түүнээс шалтгаалахгүйгээр хараат бус бие даасан байдлаар гаргаж, төр, засаг, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд үйлчлэхэд оршино. Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг судалсны үндсэн дээр статистикийн мэдээллээр хангах, мэдээллийг хэрэглэгчдэд хүргэх орчин үеийн арга хэрэгслийг ашиглах, мэдээллийн ил тод байдлыг хангах болно.

Үйл ажиллагааны энэ зорилт нь албан ёсны статистикийн үйл ажиллагааг улсын хэмжээнд давхардалгүй, нэгдсэн арга зүйгээр, үр ашигтай явуулахад чиглэнэ. Энэ нь статистикийн төв, орон нутгийн байгууллагыг мэргэжлийн удирдлага, боловсон хүчинээр хангах, тэдгээрийг давтан сургах, статистикийн шинжлэх ухааны үндэслэлтэй нэгдсэн арга зүйг боловсруулан мөрдүүлэх, тооллого, түүвэр судалгааг удирдан зохион байгуулж явуулах, мэдээ тайлангийн маягт, аргачлалыг боловсруулан мөрдүүлэх замаар хэрэгжинэ.

2003 оноос төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хуульхэрэгжсэнээр "Статистикийн тухай" хуулийг түүнтэй нийцүүлэх, НҮБ-аас статистикийн талаар баримтлах 10 зарчмыг хуульд бүрэн тусгах арга хэмжээ авахаар ажиллаж байна. Мөн статистикийн албыг дунд болон урт хугацаанд хөгжүүлэх эрхэм зорилт, зорилго, бодлого, чиглэлийг тодорхойлсон стратеги төлөвлөгөөг төв, аймаг, нийслэл, сумын түвшинг хамруулан боловсруулах ажил хийгдэж байна. Энэ төлөвлөгөөг ойрын үед гаргаж холбогдох газраар батлуулж мөрдөх болно.